



X/2021

Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15



Хураасан үр тариа өмнөх оны мөн үеэс 174.8 мянган тонн буюу 44.4 хувиар өслөө

Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2021 оны 10 дугаар сарын байдлаар 568.7 мянган тонн үр тариа, 178.8 мянган тонн төмс, 114.4 мянган тонн хүнсний ногоо хурааж, 1.1 сая тонн хадлан, 29.3 мянган тонн гар тэжээл, 2.8 мянган тонн дарш бэлтгэсэн байна.

Өмнөх оны мөн үеэс хураасан үр тариа 174.8 (44.4%) мянган тонноор, хүнсний ногоо 4.5 (4.1%) мянган тонноор, бэлтгэсэн хадлан 152.8 (15.8%) мянган тонноор тус тус өсөж, харин хураасан төмс 62.5 (25.9%) мянган тонноор, бэлтгэсэн гар тэжээл 1.3 (4.1%) мянган тонноор, дарш 0.4 (13.5%) мянган тонноор тус тус буурсан байна.

Хураасан үр тарианы 5.0-30.8 хувь Хөвсгөл, Дорнод, Увс, Булган, Төв, Сэлэнгэ аймагт, хураасан төмсний 2.3-58.0 хувь Өвөрхангай, Булган, Дархан-Уул, Ховд, Сэлэнгэ, Төв аймагт, хураасан хүнсний ногооны 2.4-28.0 хувь Өвөрхангай, Орхон, Ховд, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймагт ногдож байна.

ЗУРАГ 1. ХУРААСАН УРГАЦ, БЭЛТГЭСЭН ӨВС ХАДЛАН, ГАР ТЭЖЭЭЛ, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

	2018 X	2019 X	2020 X	2021 X	<u>2021 X</u> 2020 X
	мянган тонн				хувь
Үр тариа	416.1	397.2	393.9	568.7	144.4
Төмс	166.6	189.2	241.3	178.8	74.1
Хүнсний ногоо	95.1	91.1	109.8	114.4	104.1
Бэлтгэсэн хадлан	1 113.6	1 130.4	968.9	1 121.7	115.8
Гар тэжээл	36.5	39.6	30.6	29.3	95.9

Хураасан үр тариа Дундговь, Баян-Өлгий, Улаанбаатар хот, Хэнтий аймагт өмнөх оны мөн үеэс 3.8 тонноос 4.4 мянган тонноор буюу 22.9-53.8 хувиар буурч, бусад аймагт 13.7 тонноос 81.8 мянган тонноор буюу 5.9 хувиас 3.7 дахин өссөн байна.

Хураасан төмс Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Баян-Өлгий, Завхан, Хэнтий, Архангай, Ховд аймагт 23.4-896.5 тонноор буюу 3.9-49.6 хувиар өсөж, бусад аймагт 56.5 тонноос 50.2 мянган тонноор буюу 1.5-47.4 хувиар буурсан байна.

Хураасан хүнсний ногоо Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотод 78.1 тонноос 1.8 мянган тонноор буюу 1.7-41.9 хувиар буурч, бусад аймагт 7.5 тонноос 3.2 мянган тонноор буюу 0.5-42.0 хувиар өссөн байна.

Бэлтгэсэн хадлан Баян-Өлгий, Говьсүмбэр, Улаанбаатар хот, Сүхбаатар, Ховд, Дорнод аймагт 565.5 тонноос 20.7 мянган тонноор буюу 0.9-91.8 хувиар буурч, харин бусад аймагт 134.4 тонноос 39.7 мянган тонноор буюу 0.7-98.3 хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Тариалсан талбай гэж хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

Га-гийн ургац гэж талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.



Эх үүсвэр:

Ургац хураалт, хадлан тэжээл, бэлтгэлийн мэдээ (А-ХАА-8)

Ангилал, код:

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Хөдөө аж ахуй, байгаль орчин,
үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн
статистикч Х.Энхжавхлан
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212